



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Мөнгөний бодлогын хүүг 0.75 нэгж хувиар бууруулах тухай

Дугаар: 2013/01
Мөрдөх огноо: 2013 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 0.75 нэгж хувиар бууруулан 12.5 хувь болгох шийдвэр гаргав.

Инфляцийн хэтийн хандлага зорилтот түвшинтэй нийцтэй, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт буурч, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл багасахаар хүлээгдэж байгаа нь мөнгөний бодлогын хүүг бууруулах нөхцлийг бүрдүүлж байна.

Бодлогын хүүг бууруулснаар мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулан, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн идэвхжлийг дэмжих боломжийг олгоно.

Макро эдийн засгийн төлөв нь мөнгөний бодлогыг зөөлрүүлэх боломжийг бүрдүүлж буй хэдий ч, бодлогын шийдвэрт гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдлыг харгалзан үзлээ.

Зөвлөлийн хурлын хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ